

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Г Журамд өөрчлөлт оруулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 80 дугаар зүйлийн 12, 17 дахь заалтуудыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйлийн 12 дахь заалт:

“8.12. Энэ журмын 8.17-д зааснаас бусад тохиолдлоор компанийн үнэт цаасыг үнэт цаасны бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэр гарсны дараагийн өдрөөс эхлэн тухайн компанийн үнэт цаасны арилжааг зогсооно”,

2/ 8 дугаар зүйлийн 17 дахь заалт:

“8.17. Компанийн татан буулгах шийдвэрийн дагуу үнэт цаасыг бүртгэлээс хасуулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу үнэт цаасны бүртгэлээс хассан тухай Хорооны шийдвэр гарсны дараагийн өдрөөс эхлэн тухайн компанийн үнэт цаасны арилжааг зогсооно”.

2 дугаар зүйл. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН